

Батлав. МВХ-ны ЕРӨНХИЙЛӨГЧ

Т.БАЯРХҮҮ

**МОНГОЛЫН ВОЛЕЙБОЛЫН ХОЛБООНЫ "ҮНДЭСНИЙ ДЭЭД ЛИГ-ийн"
АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР**

1. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

Монголын волейболын холбоо

Хаяг: Монголын волейболын холбоо
МҮОХ-ны байр, 402 тоот
Чингисийн өргөн чөлөө,
Улаанбаатар 14210

Утас / Факс: 99090301

Цахим шуудангийн хаяг:

info@mva.mn

2. ТЭМЦЭЭНИЙ ХУВААРЬ

Тэмцээний өдрүүд:

2020 оны 11-р сарын 15-наас 12-р сарын 27-ны
хооронд зохион байгуулагдана.

3. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ ХОТ & ТЭМЦЭЭН БОЛОХ ГАЗАР

Улаанбаатар хот

4. ОРОЛЦОГЧ БАГУУД

- 4.1 Бие даасан клуб, аймаг, дүүргийн шигшээ багууд оролцоно.
- 4.2 Багийн тоглогч нь тухайн клубтэй гэрээ байгуулсан байх ба уг гэрээг үндэслэн аливаа маргааныг шийдвэрлэнэ.
- 4.3 Баг хооронд шилжсэн тамирчид өмнөх клубээс зөвшөөрөл авсан байна.
- 4.4 Багт нийт 12 Монгол тамирчин байна.
- 4.5 Зохион байгуулагчид нь паспорт болон холбогдох иргэний бичиг баримтыг шалгасны үндсэн дээр тэмцээнд оролцох мандатыг олгох эрхтэй.

6. БАГИЙН МЭДҮҮЛЭГ БА МЭДЭЭЛЭЛ, ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨН

- 5.1 Оролцох багууд 11-р сарын 5-ны дотор зохион байгуулах хооронд оролцох тухай батламж буюу урьдчилсан мэдүүлэг /маягт MVA0103001/-ийг илгээх шаардлагатай.
Техникийн зөвлөгөөнд авчрах зүйлс:
 - а) Эцсийн мэдүүлэг /маягт MVA0103002/
 - б) Эрүүл мэндийн хуудас /маягт MVA0103004/
 - в) Багийн ахлагчийн 2 өнгийн тоглолтын хувцас
 - г) Багийн зураг, тамирчны цээж зураг
- 5.2 Албан ёсны сугалааг 11-р сарын 9-ны 17:00 цагаас техникийн зөвлөгөөний үеэр зохион байгуулна.
- 5.3 Техникийн зөвлөгөөн дээр багийн менежер, дасгалжуулагч, ахлагч нар оролцоно.
- 5.4 Техникийн зөвлөгөөнийг Олон улсын волейболын холбооны дүрмийн дагуу удирдан явуулна.
- 5.5 Зохион байгуулагчид нь МВХ-ны тэмцээн зохион байгуулах журмыг чандлан мөрдөнө.

6. ТЭМЦЭЭНИЙ СИСТЕМ

- 6.1 Бергерийн хүснэгтийг үндэслэн тоглолтын дарааллыг тогтооно.
- 6.2 Урьдчилсан тоглолтыг 3 тойрог явуулж, 3 тойргийн нийлбэр дүнгээр 1-р гарсан баг 2-р гарсан багтай алтан медалийн төлөө, 3-р гарсан баг 4-р гарсан багтай хүрэл медалийн төлөө тоглоно.
- 6.3 Шигшээ тоглолтод багууд түрүүлж 3 хожил авсан баг нь ялагч болох нөхцөлөөр өрсөлдөх ба дээд тал нь 5 удаа тоглож болно.
- 6.4 Тэмцээн зохион байгуулах талбай дээр албан ёсны ажиллагаа эхлэхээс өмнө багууд бие халаалтын хугацаа харгалзалгүйгээр хийж болно.
- 6.5 Албан ёсны бие халаалт 17 минут үргэлжилнэ.
- 6.6 Албан ёсны мэдүүлэгт ороогүй албаны хүмүүс бие халаалтын үед талбай дээр гарч болох бөгөөд тэмцээн эхэлснээс хойш 1-р шүүгчийн зааврыг дагана.

7. ТОГЛОЛТЫН ДАРААЛАЛ, ЗОХИОН БАЙГУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

- 7.1 Зохион байгуулагч нь хэвлэл мэдээлэл, ТВ-ийн нэвтрүүлгийн улмаас тоглолтын хуваарийг өөрчлөх эрхтэй. Өөрчлөгдсөн хуваарийг тухайн багуудад 24 цагийн өмнө мэдээлэх шаардлагатай.
- 7.2 Тэмцээнийг ОУВХ-ны тоглолтын дүрмийн дагуу болон МВХ-ны "Тэмцээн зохион байгуулах журмын" дагуу явуулна.
- 7.3 МВХ-ны Шүүгчдийн зөвлөлөөс томилогдсон шүүгчид тэмцээнийг шүүнэ.
- 7.4 Тэмцээний туршид ажиллах эмчийг Зохион байгуулах хороо томилно.
- 7.5 Эмнэлгийн үзлэг, уулзалтын өрөөг Зохион байгуулах хороо бэлдсэн байна.

8. ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ БА ХЯНАЛТ

- 8.1 Багийн бүх гишүүд нь сүүлийн 1 сарын хугацаанд баталгаажуулсан эрүүл мэндийн хуудсыг /маягт MVA0103004/ бүрдүүлнэ.
- 8.2 Анхны яаралтай тусламжийг Зохион байгуулах хороо үзүүлнэ.
- 8.3 Баг нь бүх гишүүдийнхээ эрүүл мэндийн даатгалыг хариуцна.

9. БЭЛТГЭЛ

- 9.1 Багууд бэлтгэл хийх хуваариа тоглолтын хуваарьтай зохицуулсан байна.

10. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

- 10.1 Багуудын танилцуулга, тэмцээнд оролцож буй амжилтын талаар тухайн багууд хэвлэлийн бага хурал хийх болон зохион байгуулагчдын зүгээс тэмцээнийг сурталчилна.
- 10.2 Тэмцээний өдөр тутмын дүн мэдээг багуудад болон хэвлэл мэдээллийн байгууллагад тараана.

11. АЛБАН ЁСНЫ ДҮРЭМ, БӨМБӨГ

- 11.1 Олон улсын волейболын холбооны дүрмийн дагуу тэмцээнийг зохион явуулна. Тэмцээн эхлэхээс өмнө хийгдсэн шүүгчдийн шалгалтын дүнгээр ямар нэгэн өөрчлөлт гарч болох ба техникийн зөвлөгөөн дээр танилцуулна.

- 11.2 Тэмцээнийг MIKASA Volleyball V200 W маркийн бөмбөгөөр явуулна.

12. ХУВЦАС

- 12.1 Тоглолтын хувцас Монгол улсын стандартад нийцсэн байна. Баг тус бүр 2 өнгийн хувцастай байх ба зөвхөн нэрийн мэдүүлэгт баталгаажуулсан хувцсыг өмсөнө. **МВХ-ноос зохион байгуулагдаж буй тэмцээнд оролцож байгаа багууд тоглолтын болон бэлтгэлийн хувцсан /өмсгөл/ дээр төрийн далбааг ашиглахыг хориглох бөгөөд төрийн далбаатай өмсгөл хувцастай тоглолтонд оролцуулахгүй. /Төрийн далбааг зөвхөн шигшээ багийн тамирчдын өмсгөл хувцсан дээр ашиглана**
- 12.2 Хувцсыг буруу өмсөх, стандартыг дагаж мөрдөөгүй тохиолдолд дүрмийн дагуу торгууль хүлээнэ. (ОУВХ-ны Тэмцээн зохион байгуулах дүрмийн 4.9.5 дагуу)
- 12.3 Тоглолтын хувцсыг урьдчилсан шалгалтын үеэр шалгуулж баталгаажуулна.
- 12.4 Хажуугийн сандал дээр суух багийн албаны хүмүүс дараах шаардлагуудын аль нэгийг хангана:
- а) Багийн бүх гишүүдийн адил ижил өнгийн хувцас өмсөх
 - б) Албан ёсны костюм өмсөж, зангиа зүүх
 - в) Бэлтгэл хангагчаас бусад нь албан ёсны хувцас өмсөх

13. МАРГААН

- 13.1 Тухайн тоглолт дууссанаас 30 минутын хугацаанд багийн менежер эсвэл ахлах дасгалжуулагч нь гомдол гаргах эрхтэй.
- 13.2 Маргаан гаргах тус бүрт 300,000 төгрөгийг барьцаа болгон тушаана. Хэрэв нотлогдохгүй бол уг барьцаа буцаан олгогдохгүй.

14. БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- 14.1 Баг тус бүр 16 гишүүнтэй байна. Үүнд: 12 тоглогч, 1 багийн менежер, 1 ахлах дасгалжуулагч, 1 туслах дасгалжуулагч, 1 массажист буюу эмч,
- 14.2 Багийн албаны хүмүүс хажуугийн сандал дээр суух ба онцгой тохиолдлоос бусад үед өөрчлөлт хийхийг хориглоно.
- 14.3 Багийн тоглогчийн тоо хамгийн багадаа 10 байж болно.

15. САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ

- 15.1 Баг тус бүр дараах зардлыг хариуцна:
- а) Тэмцээнд оролцох эрхийн төлбөр баг тус бүр 8,000,000 төгрөг
 - б) Тамирчид, дасгалжуулагч нар МВХ-ны лицензийн дэвтэртэй байна.
 - в) Гишүүнчлэлийн хураамж багийн гишүүн тус бүр 20000 төгрөг
- 15.2 Зохион байгуулах хороо нь:
- а) Эмнэлгийн анхны тусламж
 - б) Тэмцээний заалны түрээс болон зохион байгуулалтын зардал
 - в) Шууд нэвтрүүлгийн хөлс